



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 314


Улсын төслийн тухай

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам" болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2005 оны 1/89 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Данран овогтой Мөнхжаргал, Болат овогтой Айбек, Каусылгазы овогтой Женисгүл нарыг 2005-2006 оны хичээлийн жилээс Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яам хооронд байгуулсан хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яамны Санкт-Петербург хотын Хуулийн Их сургуулийн докторантурт Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар 3 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.



П.ЦАГААН

0000171